



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19

№

72

танай

ны №

т

**СЭЛЭНГЭ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ө.БҮЖИНЛХАМ ТАНАА**

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар нийт 873.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 873.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ





**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.12 № 03

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ө.БУЖИНЛХАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ сумын ЭМТ нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж, 3 хөтөлбөр зориулалт арга хэмжээний хүрээнд 1,063,901.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,009,239.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Тайланд онд 12,611.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 199,162.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 64,967.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Булган аймгийн ЭМГ болон ЭМЯ-наас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Билний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант

үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны А/21 тоот захирамжаар 29 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталснаас 2024 онд гүйцэтгэлээр 23 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжтой нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/57/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он</p>	<p>Булган аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч : Ж.Энхцоодол Утас:70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjमितsetseg@gmail.com Ахлах Аудитор: Б.Нарантуяа Утас:99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,053,600.69	321,040,129.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,362,918.72	1,923,556.08
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,362,918.72	1,923,556.08
3121	Төгрөг	17,362,918.72	1,923,556.08
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	17,362,918.72	1,923,556.08
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	23,293,711.00	181,949,862.87
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,270,678.00	1,400,449.82
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,023,033.00	180,549,413.05
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	123,396,970.97	137,166,710.61
351	Түүхий эд материал	62,937,989.10	59,326,599.29
3511	Тусгай зориулалттай материал	2,115,000.00	14,759,100.00
3513	Эм боох материал	60,822,989.10	44,567,499.29
354	Хангамжийн материал	59,986,981.87	77,275,111.32
3541	Бичиг хэргийн материал	643,060.00	846,700.00
3542	Аж ахуйн материал	15,158,100.00	37,871,150.00
3544	Түлш, шатах тослох материал	7,724,000.00	5,904,000.00
3545	Барилгын засварын материал		179,000.00
3546	Хүнсний материал	6,994,706.00	1,622,610.00
3547	Бусад хангамжийн материал	29,467,115.87	30,851,651.32
356	Мал амьтад	472,000.00	565,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	477,111,141.10	641,547,076.01
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	Үндсэн хөрөнгө	477,111,141.10	641,547,076.01
392	Биет хөрөнгө	456,633,141.10	621,564,076.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	339,504,537.36	339,504,537.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,019,472.21	-114,149,843.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,937,898.00	257,100,801.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,854,324.11	-49,292,157.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	217,307,669.12	294,886,190.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,363,733.03	-109,135,353.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,385,500.00	10,385,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,264,934.03	-7,735,600.25
393	Биет бус хөрөнгө	20,478,000.00	19,983,000.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-540,000.00	-1,035,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,668,000.00	19,668,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	641,164,741.79	962,587,205.57
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	641,164,741.79	962,587,205.57
51	Засгийн газрын хувь оролцоо	641,164,741.79	962,587,205.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279,647,290.31	279,647,290.31
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	130,577,721.01	452,000,184.79
5121	Өмнөх үеийн үр дүн	130,577,721.01	130,577,721.01
5122	Тайлант үеийн үр дүн		321,422,463.78
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,939,730.47	230,939,730.47
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	641,164,741.79	962,587,205.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,476,987,905.22	1,476,987,905.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	322,465,859.70	322,465,859.70
120	Нийтлэг татварын бус орлого	322,465,859.70	322,465,859.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	803,980.00	803,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	803,980.00	803,980.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	264,130,075.31	264,130,075.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	57,531,804.39	57,531,804.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,154,522,045.52	1,154,522,045.52
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,781,400.00	59,781,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,781,400.00	59,781,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,094,740,645.52	1,094,740,645.52
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,094,740,645.52	1,094,740,645.52
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,155,368,441.44	1,155,368,441.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,155,368,441.44	1,155,368,441.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,040,054.21	1,155,040,054.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,499,932.52	656,499,932.52
210101	Үндсэн цалин	364,078,724.06	364,078,724.06
210102	Нэмэгдэл	239,208,330.46	239,208,330.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,529,000.00	14,529,000.00

210104	Урамшуулал	38,683,878.00	38,683,878.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,560,905.77	68,560,905.77
210201	Тэтгэврийн даатгал	48,200,247.20	48,200,247.20
210202	Тэтгэмжийн даатгал	5,162,274.74	5,162,274.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,655,172.83	2,655,172.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,252,513.46	2,252,513.46
210205	Эрүүл мэндийн даатгал	10,290,697.54	10,290,697.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,917,012.77	54,917,012.77
210301	Гэрэл, цахилгаан	4,552,932.77	4,552,932.77
210302	Түлш, халаалт	49,651,080.00	49,651,080.00
210303	Цэвэр, бохир ус	713,000.00	713,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,282,319.05	50,282,319.05
210401	Бичиг хэрэг	3,231,110.00	3,231,110.00
210402	Тээвэр, шатахуун	21,780,360.00	21,780,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,862,400.00	1,862,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,048,200.00	2,048,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,169,150.00	3,169,150.00
210408	Бараа материал акталсны зардал	18,191,099.05	18,191,099.05
2105	Нормативт зардал	126,491,083.70	126,491,083.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,603,487.70	106,603,487.70
210502	Хоол, хүнс	19,887,596.00	19,887,596.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,374,386.00	22,374,386.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,267,837.00	5,267,837.00
210604	Урсгал засвар	17,106,549.00	17,106,549.00
2107	Томилолт, зочны зардал	4,055,200.00	4,055,200.00
210702	Дотоод албан томилолт	4,055,200.00	4,055,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,183,524.00	56,183,524.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,516,228.00	55,516,228.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,096.00	49,096.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	427,400.00	427,400.00
210807	Газрын төлбөр	40,800.00	40,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,675,690.40	115,675,690.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,370,200.00	3,370,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,305,490.40	112,305,490.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,387.23	328,387.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,000.00	76,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	76,000.00	76,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	252,387.23	252,387.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	252,387.23	252,387.23
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	321,619,463.78	321,619,463.78
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	197,000.00	197,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	197,000.00	197,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-197,000.00	-197,000.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	321,422,463.78	321,422,463.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	993,799,645.47	993,799,645.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	803,980.00	803,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	803,980.00	803,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	803,980.00	803,980.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	803,980.00	803,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	992,995,665.47	992,995,665.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,781,400.00	59,781,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,781,400.00	59,781,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	933,214,265.47	933,214,265.47
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	933,214,265.47	933,214,265.47
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	996,627,658.11	996,627,658.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	996,627,658.11	996,627,658.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	996,375,270.88	996,375,270.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	656,499,932.52	656,499,932.52
210101	Үндсэн цалин	364,078,724.06	364,078,724.06
210102	Нэмэгдэл	239,208,330.46	239,208,330.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,529,000.00	14,529,000.00
210104	Урамшуулал	38,683,878.00	38,683,878.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,690,677.59	65,690,677.59
210201	Тэтгэврийн даатгал	45,330,019.02	45,330,019.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,162,274.74	5,162,274.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,655,172.83	2,655,172.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,252,513.46	2,252,513.46
210205	Эрүүл мэндийн даатгал	10,290,697.54	10,290,697.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,279,012.77	53,279,012.77
210301	Гэрэл, цахилгаан	4,552,932.77	4,552,932.77
210302	Түлш, халаалт	47,831,080.00	47,831,080.00
210303	Цэвэр, бохир ус	895,000.00	895,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,463,010.00	37,463,010.00

210401	Бичиг хэрэг	3,134,250.00	3,134,250.00
210402	Тээвэр, шатахуун	21,780,360.00	21,780,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,544,400.00	2,544,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,989,900.00	2,989,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,014,100.00	7,014,100.00
2105	Нормативт зардал	93,664,465.00	93,664,465.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,398,965.00	75,398,965.00
210502	Хоол, хүнс	14,515,500.00	14,515,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000.00	3,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,811,549.00	20,811,549.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,526,000.00	3,526,000.00
210604	Урсгал засвар	17,285,549.00	17,285,549.00
2107	Томиллолт, зочны зардал	4,055,200.00	4,055,200.00
210702	Дотоод албан томиллолт	4,055,200.00	4,055,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,907,124.00	56,907,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,516,228.00	55,516,228.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,096.00	49,096.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	427,400.00	427,400.00
210807	Газрын төлбөр	40,800.00	40,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	723,600.00	723,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,004,300.00	8,004,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,004,300.00	8,004,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,387.23	252,387.23
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	252,387.23	252,387.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	252,387.23	252,387.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-2,828,012.64	-2,828,012.64
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,611,350.00	12,611,350.00
	Дотоод эх үүсвэрээр	12,611,350.00	12,611,350.00
222001	Тоног төхөөрөмж	12,611,350.00	12,611,350.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12,611,350.00	-12,611,350.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-15,439,362.64	-15,439,362.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,362,918.72	17,362,918.72
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,923,556.08	1,923,556.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЭГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8				
9				
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	130,577,721.01	641,164,741.79
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			321,422,463.78	321,422,463.78
18				
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,647,290.31	230,939,730.47	452,000,184.79	962,587,205.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьц уулап т
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,063,901,000.00	1,009,239,008.11	54,661,991.89	94.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,063,901,000.00	996,627,658.11	67,273,341.89	93.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,901,000.00	996,375,270.88	67,525,729.12	93.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,724,100.00	656,499,932.52	28,224,167.48	95.88
210101	Үндсэн цалин	379,192,000.00	364,078,724.06	15,113,275.94	96.01
210102	Нэмэгдэл	267,004,600.00	239,208,330.46	27,796,269.54	89.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,480,000.00	14,529,000.00	-6,049,000.00	171.33
210104	Урамшуулал	30,047,500.00	38,683,878.00	-8,636,378.00	128.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,590,600.00	65,690,677.59	19,899,922.41	76.75
210201	Тэтгэврийн даатгал	58,201,600.00	45,330,019.02	12,871,580.98	77.88
210202	Тэтгэмжийн даатгал	6,847,300.00	5,162,274.74	1,685,025.26	75.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,423,600.00	2,655,172.83	768,427.17	77.55
210204	Ажилгүйдлийн даатгал	3,423,600.00	2,252,513.46	1,171,086.54	65.79
210205	Эрүүл мэндийн даатгал	13,694,500.00	10,290,697.54	3,403,802.46	75.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,531,400.00	53,279,012.77	252,387.23	99.53
210301	Гэрэл, цахилгаан	4,799,900.00	4,552,932.77	246,967.23	94.85
210302	Түлш, халаалт	47,831,500.00	47,831,080.00	420	100
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	895,000.00	5,000.00	99.44
2104	Хангамж, бараа материалын зардал	39,470,300.00	37,463,010.00	2,007,290.00	94.91
210401	Бичиг хэрэг	3,153,900.00	3,134,250.00	19,650.00	99.38
210402	Тээвэр, шатахуун	23,700,000.00	21,780,360.00	1,919,640.00	91.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,561,200.00	2,544,400.00	16,800.00	99.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,100.00	2,989,900.00	26,200.00	99.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,039,100.00	7,014,100.00	25,000.00	99.64
2105	Нормативт зардал	94,109,700.00	93,664,465.00	445,235.00	99.53

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,865,600.00	75,398,965.00	466,635.00	99.38
210502	Хоол, хүнс	14,493,900.00	14,515,500.00	-21,600.00	100.15
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,200.00	3,750,000.00	200	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,430,200.00	20,811,549.00	12,618,651.00	62.25
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,138,300.00	3,526,000.00	12,612,300.00	21.85
210604	Урсгал засвар	17,291,900.00	17,285,549.00	6,351.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	5,500,000.00	4,055,200.00	1,444,800.00	73.73
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	4,055,200.00	1,444,800.00	73.73
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,513,900.00	56,907,124.00	2,606,776.00	95.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,069,400.00	55,516,228.00	2,553,172.00	95.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00		100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	49,096.00	49,904.00	49.59
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	431,100.00	427,400.00	3,700.00	99.14
210807	Газрын төлбөр	40,800.00	40,800.00		100
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	723,600.00	723,600.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,030,800.00	8,004,300.00	26,500.00	99.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,030,800.00	8,004,300.00	26,500.00	99.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		252,387.23	-252,387.23	
2132	Бусад урсгал шилжүүлэг				
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		252,387.23	-252,387.23	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		252,387.23	-252,387.23	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		12,611,350.00	12,611,350.00	
	Дотоод эх үүсвэрээр		12,611,350.00	12,611,350.00	
222001	Тоног төхөөрөмж		12,611,350.00	12,611,350.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		993,799,645.47	993,799,645.4	7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				

132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		59,781,400.00	59,781,400.00	-
132001	Орон нутгийн төсвөөс		59,781,400.00	59,781,400.00	-
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				933,214,265.4
134			933,214,265.47		7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		933,214,265.47		7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		803,980.00	-803,980.00	
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		803,980.00	-803,980.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17,362,918.72	17,362,918.72	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,923,556.08	-1,923,556.08	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ сумын ЭМТ нь "Үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийн болон сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулж, өвчлөлийг бууруулахад оршино" гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

2024 оны зорилтоо тодорхойлон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 7 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ төлөвлөн сумын Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласнаас 2 ажил дутуу хэрэгжсэнээр 2024 оны төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 91.3 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэд үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй жигд хүртээмжтэй хүргэх, ажилчдын нийгмийн баталгааг хангаж ажиллах чиг үүрэгтэй ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДЕГ-ын тогтоолууд, хууль журмууд, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль,

Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол тосгоны төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичиг, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын баг болон дотоод хяналтын багаас хэрэгжүүлж буй төлөвлөлтийг үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 тоот журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 276741,4 мянган төгрөгөөр буюу 29,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,362.90	1,923.60	15,439.30
Авлага	23,293.70	181,949.90	-158,656.20
Бараа материал	123,397.00	137,166.70	-13,769.70
Үндсэн хөрөнгө	641,547.10	922,895.00	-281,347.90
Нийт хөрөнгө	805,600.70	1,243,935.20	-438,334.50
Өр төлбөр	-	-	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	279,647.30	279,647.30	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	805,600.70	1,243,935.20	-438,334.50

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 13,769.7 мянган төгрөгөөр өссөн, үндсэн хөрөнгө 281,347.9 төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,094,740.6 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 59,781.4 мянган төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийг төслийн саналын дүнгээр төсөв баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 933,214.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 59,781.4 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 803.9 мянган төгрөг нийт 993,799.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 996,627.6 төгрөг зарцуулж 1,923,6 мянган төгрөгийн үлдэгдэл гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эрүүл мэндийн тусламж	0	0	0	0%
2	80302-Нэг иргэн	756,146,900.0	711,756,073.47	44,390,826.53	94%
3	81603- Үндсэн тусламж	256,457,700.0	221,458,192.0	34,999,508.0	86%
4	83601-Олон улсын байгууллагаас олгосон	298,400.0	298,380.0	20.0	99%
5	83603-Дээд шатнаас хуваарилсан	225,600.0	0	0	0%
6	80111-ОН-ын урсгал үйл ажиллагаа	59781000	59781000	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ

сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймгийн аудитын газарт 2024 оны 1 сарын 24-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,155,368.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,330.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,997.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ. Аудитаар 29 горим хэрэгжүүллээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 171 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 169 мэдээг бүрэн мэдээлсэн, хугацаа хоцорсон бүртгэгдээгүй, тайлагнаагүй 2 мэдээ үлдсэн, тайлагнаагүй 2 мэдээ нь хуулийн хугацаа нь 2025 оны 4 сард 2024 оны санхүүгийн тайлангийн дүнг тайлагнах 2 мэдээ тул хугацаа болоогүй 2 мэдээ байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, спидометрийн заалтыг дахин нягталж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягталж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж.

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримталж ажиллаагүй. Зөвлөмж.

3 Хувь хүнд ажлын хөлс олгохдоо 696.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1.2.Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах заалтыг баримталж ажиллаагүй. Төлбөрийн акт тогтоох.

Үндсэн хөрөнгийн элэгдэл 18,931.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна . Энэ нь УСНБББОУС-12,Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Залруулга.

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 7 нэр төрлийн нийт 22.2 мянган төгрөгийн эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Зөвлөмж

Бараа материалын тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 176.7 мянган төгрөгийн бараа материал дутсан байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Төлбөрийн акт тбгтоох.

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, нярвын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Зөвлөмж

Анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн

хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ " хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	137.2	1	137.2	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2	0	2	0	100
Залруулга					
Нийт дүн	3	137.2	3	137.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, системийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно", "Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 873,5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 873,5 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 02/30

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:



Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах" заалтыг баримталж ажиллаагүй 696,780.0 (Зургаан зуун ерөн зургаан мянга долоон зуун наян) төгрөг суутгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 696,780.0 (Зургаан зуун ерөн зургаан мянга долоон зуун наян) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ сумын ЭМТ-ийн дарга (Ө.Бүжинлхам), нягтлан бодогч (Г.Ариунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР  Г.МАЙЦЭЦЭГ

631744
ТӨАМ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 01/29

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Сэлэнгэ сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Бараа материалын тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 176,760.0 (Нэг зуун далан зургаан мянга долоон зуун жаран) төгрөгийн бараа материал дутагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 176,760.0 (Нэг зуун далан зургаан мянга долоон зуун жаран) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ сумын ЭМТ-ийн дарга (Ө.Бүжинлхам), нягтлан бодогч (Г.Ариунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР  Г.МАЙЦЭЦЭГ

631744
Г.МАЙЦЭЦЭГ